**МОНГОЛ УЛС**
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 13 өдөр Дугаар А/578 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5," Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал батлах тухай" Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоол аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар, "тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 312 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Худалдан авах ажиллагааны газарт чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэсэн байгууллагын түвшний үйл явцын шинжилгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Цэнд-Аюуш (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга)
Гишүүд: Б.Болд (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга)
М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)
Х.Мөнх-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны ахлах мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга: Д.Төмөр (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааны газрын чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэсэн байгууллагын түвшний үйл явцын шинжилгээг хууль тогтоомжийн дагуу хийж баталгаажуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

d/zahiramj

6712011375